АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Орхон-Чулуут голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2022/33/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>2022 он | Дарга, Тэргүүлэх аудитор:Т.Байгалмаа<br>Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaa.T@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар<br>Утас: 70332860 Цахим хаяг: Nerguibaatar.d@audit.gov.mn<br>Аудитор: Ж.Мөнгөншагай<br>Утас:90909190<br>Цахим хаяг: Mungunshagai.J@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. Агуулга

1.Аудитын дүгнэлт
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....8
3. Аудитын тайлан....8
3.1 Ерөнхий зүйл.... 9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.... 9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.... 10
3.4 Материаллаг байдал.... 10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.... 10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .... 11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.... 12
3.8 Аудитын гол асуудал.... 12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .... 12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .... 12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.... 13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .... 13
4. Аудитын илрүүлэлт ....13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....14

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БОГ | Байгаль орчны газар |
| БОАЖЯ | Байгаль орчин аялал жуулчлалын сайд |

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс:976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.25 № 89
танай ____________-ны № ____________-т

ОРХОН-ЧУЛУУТ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА Ч.ОТГОНБААТАР ТАНАА

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Орхон-Чулуут голын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Орхон-Чулуут голын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */ төгрөгөөр /*

| № | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **13,087,380.00** | **13,027,880.00** |
| 2 | **БАРАА МАТЕРИАЛ** | **13,087,380.00** | **13,027,880.00** |
| 3 | **Хангамжийн материал** | **13,087,380.00** | **13,027,880.00** |
| 4 | Аж ахуйн материал | 13,087,380.00 | 13,027,880.00 |
| 5 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **306,001,155.14** | **354,092,212.33** |
| 6 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **306,001,155.14** | **354,092,212.33** |
| 7 | **Биет хөрөнгө** | **276,001,155.14** | **324,092,212.33** |
| 8 | Барилга, байгууламж, орон сууц | 114,702,000.00 | 124,679,637.00 |
| 9 | Хуримтлагдсан элэгдэл | -8,613,499.15 | -9,569,349.15 |
| 10 | Авто-тээврийн хэрэгсэл | 11,160,000.00 | 53,800,000.00 |
| 11 | Хуримтлагдсан элэгдэл | 0.00 | -1,674,000.00 |
| 12 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 232,696,341.53 | 232,696,341.53 |
| 13 | Хуримтлагдсан элэгдэл | -79,926,432.10 | -80,675,861.84 |
| 14 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 30,665,787.65 | 30,665,787.65 |
| 15 | Хуримтлагдсан элэгдэл | -24,683,042.79 | -25,830,342.86 |
| 16 | **Биет бус хөрөнгө** | **30,000,000.00** | **30,000,000.00** |
| 17 | Програм хангамж | 770,000.00 | 770,000.00 |
| 18 | Хуримтлагдсан элэгдэл | -770,000.00 | -770,000.00 |
| 19 | Бусад биет бус хөрөнгө | 30,000,000.00 | 30,000,000.00 |
| 20 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **319,088,535.14** | **367,120,092.33** |
| 21 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **8,380.00** | **0.00** |
| 22 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **8,380.00** | **0.00** |
| 23 | **Өглөг** | **8,380.00** | **0.00** |
| 24 | **Бусад өглөг** | **8,380.00** | **0.00** |
| 25 | Байгууллагад төлөх өглөг | 8,380.00 | 0.00 |
| 26 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **319,080,155.14** | **367,120,092.33** |
| 27 | **Засгийн газрын хувь оролцоо** | **319,080,155.14** | **367,120,092.33** |
| 28 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 30,000,000.00 | 30,000,000.00 |
| 29 | **Хуримтлагдсан үр дүн** | **289,080,155.14** | **337,120,092.33** |
| 30 | Өмнөх үеийн үр дүн | 282,307,369.31 | 289,080,155.14 |
| 31 | Тайлант үеийн үр дүн | 6,772,785.83 | 48,039,937.19 |
| 32 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **319,088,535.14** | **367,120,092.33** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */ төгрөгөөр /*

| № | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **256,593,786.00** | **304,259,837.00** |
| 2 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **11,163,500.00** | **52,617,637.00** |
| 3 | **Нийтлэг татварын бус орлого** | **11,163,500.00** | **52,617,637.00** |
| 4 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **3,500.00** | **0.00** |
| 5 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,500.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 11,160,000.00 | 52,617,637.00 |
| **7** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **245,430,286.00** | **251,642,200.00** |
| **8** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **230,916,000.00** | **243,142,200.00** |
| **9** | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 230,916,000.00 | 243,142,200.00 |
| **10** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **14,514,286.00** | **8,500,000.00** |
| **11** | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 714,286.00 | 0.00 |
| **12** | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 13,800,000.00 | 8,500,000.00 |
| **13** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **249,821,000.17** | **256,219,899.81** |
| **14** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **249,821,000.17** | **256,219,899.81** |
| **15** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **249,817,379.96** | **224,327,150.74** |
| **16** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **160,864,534.15** | **133,997,346.93** |
| **17** | Үндсэн цалин | 159,809,027.15 | 102,589,245.03 |
| **18** | Нэмэгдэл | 537,900.00 | 26,823,885.88 |
| **19** | Унаа хоолны хөнгөлөлт | 517,607.00 | 4,584,216.02 |
| **20** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **18,929,200.00** | **18,366,200.00** |
| **21** | Тэтгэврийн даатгал | 12,857,000.00 | 13,210,939.54 |
| **22** | Тэтгэмжийн даатгал | 1,518,100.00 | 1,288,813.97 |
| **23** | ҮОМШӨ-ний даатгал | 1,214,400.00 | 1,031,211.15 |
| **24** | Ажилгүйдлийн даатгал | 303,700.00 | 257,602.82 |
| **25** | Эрүүл мэндийн даатгал | 3,036,000.00 | 2,577,632.52 |
| **26** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **19,734,780.00** | **14,009,800.00** |
| **27** | Гэрэл, цахилгаан | 787,175.00 | 0.00 |
| **28** | Түлш, халаалт | 15,204,162.00 | 9,635,641.00 |
| **29** | Цэвэр, бохир ус | 638,405.00 | 414,159.00 |
| **30** | Байрны түрээс | 3,105,038.00 | 3,960,000.00 |
| **31** | **Хангамж, бараа материалын зардал** | **35,413,286.00** | **15,633,340.00** |
| **32** | Бичиг хэрэг | 10,557,400.00 | 3,321,770.00 |
| **33** | Тээвэр, шатахуун | 21,855,786.00 | 9,303,990.00 |
| **34** | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,205,300.00 | 1,066,370.00 |
| **35** | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 794,800.00 | 1,941,210.00 |
| **36** | **Нормативт зардал** | **780,000.00** | **0.00** |
| **37** | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 780,000.00 | 0.00 |
| **38** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **356,400.00** | **0.00** |
| **39** | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 356,400.00 | 0.00 |
| **40** | **Томилолт, зочны зардал** | **6,628,500.00** | **7,670,000.00** |
| **41** | Гадаад албан томилолт | 0.00 | 0.00 |
| **42** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **716,800.00** | **28,434,584.00** |
| **43** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0.00 | 28,194,384.00 |
| **44** | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 148,500.00 | 0.00 |
| **45** | Даатгалын үйлчилгээ | 249,000.00 | 0.00 |
| **46** | Тээврийн хэрэгслийн татвар | 69,300.00 | 4,900.00 |
| **47** | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 0.00 | 0.00 |
| **48** | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 250,000.00 | 235,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 49 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **6,393,879.81** | **6,215,879.81** |
| 50 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,541,300.00 | 1,689,300.00 |
| 51 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 2,852,579.81 | 4,526,579.81 |
| 52 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,620.21** | **31,892,749.07** |
| 53 | **Бусад урсгал шилжүүлэг** | **0.00** | **31,563,000.00** |
| 54 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 31,563,000.00 |
| 55 | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **3,620.21** | **329,749.07** |
| 56 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,620.21 | 329,349.07 |
| 57 | Хөрөнгийн | 0.00 | 0.00 |
| 58 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 400.00 |
| 59 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **6,772,785.83** | **48,039,937.19** |
| 60 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **6,772,785.83** | **48,039,937.19** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */ төгрөгөөр/*

| № | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **30,000,000.00** | **0.00** | **284,335,169.31** | **314,335,169.31** |
| 2 | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **0.00** | **0.00** | **-2,027,800.00** | **-2,027,800.00** |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **30,000,000.00** | **0.00** | **282,307,369.31** | **312,307,369.31** |
| 4 | **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | **6,772,785.83** | **6,772,785.83** |
| 5 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **30,000,000.00** | **0.00** | **289,080,155.14** | **319,080,155.14** |
| 6 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **30,000,000.00** | **0.00** | **289,080,155.14** | **319,080,155.14** |
| 7 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **30,000,000.00** | **0.00** | **289,080,155.14** | **319,080,155.14** |
| 8 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 48,039,937.19 | 48,039,937.19 |
| 9 | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **30,000,000.00** | **0.00** | **337,120,092.33** | **367,120,092.33** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */ төгрөгөөр /*

| № | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **246,430,486.00** | **251,642,200.00** |
| 2 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 3,500.00 | 0.00 |
| 3 | **Нийтлэг татварын бус орлого** | 3,500.00 | 0.00 |
| 4 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 3,500.00 | 0.00 |
| 5 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,500.00 | 0.00 |
| 6 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 246,426,986.00 | 251,642,200.00 |
| 7 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 230,916,000.00 | 243,142,200.00 |
| 8 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 230,916,000.00 | 243,142,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **9** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 15,510,986.00 | 8,500,000.00 |
| **10** | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 996,700.00 | 0.00 |
| **11** | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 714,286.00 | 0.00 |
| **12** | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 13,800,000.00 | 8,500,000.00 |
| **13** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **246,430,486.00** | **251,642,200.00** |
| **14** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **246,430,486.00** | **251,642,200.00** |
| **15** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **246,426,865.79** | **219,749,450.93** |
| **16** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **142,545,699.79** | **136,043,350.93** |
| **17** | Үндсэн цалин | 96,727,299.79 | 102,271,649.03 |
| **18** | Нэмэгдэл | 38,341,100.00 | 29,187,485.88 |
| **19** | Унаа хоолны хөнгөлөлт | 7,477,300.00 | 4,584,216.02 |
| **20** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **18,929,200.00** | **18,366,200.00** |
| **21** | Тэтгэврийн даатгал | 13,227,400.00 | 12,782,917.92 |
| **22** | Тэтгэмжийн даатгал | 1,425,500.00 | 1,395,820.52 |
| **23** | ҮОМШӨ-ний даатгал | 1,140,300.00 | 1,116,816.38 |
| **24** | Ажилгүйдлийн даатгал | 285,200.00 | 279,004.14 |
| **25** | Эрүүл мэндийн даатгал | 2,850,800.00 | 2,791,641.04 |
| **26** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **19,734,780.00** | **14,009,800.00** |
| **27** | Гэрэл, цахилгаан | 2,275,480.00 | 52,599.00 |
| **28** | Түлш, халаалт | 11,849,200.00 | 9,635,641.00 |
| **29** | Цэвэр, бохир ус | 1,650,100.00 | 361,560.00 |
| **30** | Байрны түрээс | 3,960,000.00 | 3,960,000.00 |
| **31** | **Хангамж, бараа материалын зардал** | **27,341,786.00** | **14,299,800.00** |
| **32** | Бичиг хэрэг | 2,277,400.00 | 2,626,960.00 |
| **33** | Тээвэр, шатахуун | 21,855,786.00 | 9,166,900.00 |
| **34** | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,205,300.00 | 1,312,140.00 |
| **35** | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,003,300.00 | 1,193,800.00 |
| **36** | **Нормативт зардал** | **641,500.00** | **641,500.00** |
| **37** | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 641,500.00 | 641,500.00 |
| **38** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **356,400.00** | **356,400.00** |
| **39** | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 356,400.00 | 356,400.00 |
| **40** | **Томилолт, зочны зардал** | **6,628,500.00** | **7,670,000.00** |
| **41** | Дотоод албан томилолт | 6,628,500.00 | 7,670,000.00 |
| **42** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **26,987,400.00** | **25,873,100.00** |
| **43** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 26,270,600.00 | 25,632,900.00 |
| **44** | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 148,500.00 | 0.00 |
| **45** | Даатгалын үйлчилгээ | 249,000.00 | 0.00 |
| **46** | Тээврийн хэрэгслийн татвар | 69,300.00 | 4,900.00 |
| **47** | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 250,000.00 | 235,300.00 |
| **48** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **3,261,600.00** | **2,489,300.00** |
| **49** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,261,600.00 | 2,489,300.00 |
| **50** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,620.21** | **31,892,749.07** |
| **51** | **Бусад урсгал шилжүүлэг** | **0.00** | **31,563,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **52** | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 31,563,000.00 |
| **53** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **3,620.21** | **329,749.07** |
| **54** | Хаагдсан данс | 0.00 | 0.00 |
| **55** | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,620.21 | 329,349.07 |
| **56** | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 400.00 |
| **57** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **0.00** | **0.00** |
| **58** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| **59** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *(/ төгрөгөөр/)*

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэлийн | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **243,142,200.00** | **242,812,850.93** | **329,349.07** | **99.86** |
| 2 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **243,142,200.00** | **242,812,850.93** | **329,349.07** | **99.86** |
| 3 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **211,579,200.00** | **211,249,850.93** | **329,349.07** | **99.84** |
| 4 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **136,045,700.00** | **136,043,350.93** | **2,349.07** | **100.00** |
| 5 | Үндсэн цалин | 98,272,900.00 | 102,271,649.03 | **-3,998,749.03** | **104.07** |
| 6 | Нэмэгдэл | 28,583,400.00 | 29,187,485.88 | **-604,085.88** | **102.11** |
| 7 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,189,400.00 | 4,584,216.02 | **4,605,183.98** | **49.89** |
| 8 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **18,366,200.00** | **18,366,200.00** | **0.00** | **100.00** |
| 9 | Тэтгэврийн даатгал | 12,924,300.00 | 12,782,917.92 | **141,382.08** | **98.91** |
| 10 | Тэтгэмжийн даатгал | 1,360,500.00 | 1,395,820.52 | **-35,320.52** | **102.60** |
| 11 | ҮОМШӨ-ний даатгал | 1,088,400.00 | 1,116,816.38 | **-28,416.38** | **102.61** |
| 12 | Ажилгүйдлийн даатгал | 272,100.00 | 279,004.14 | **-6,904.14** | **102.54** |
| 13 | Эрүүл мэндийн даатгал | 2,720,900.00 | 2,791,641.04 | **-70,741.04** | **102.60** |
| 14 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **14,010,200.00** | **14,009,800.00** | **400.00** | **100.00** |
| 15 | Гэрэл, цахилгаан | 194,100.00 | 52,599.00 | **141,501.00** | **27.10** |
| 16 | Түлш, халаалт | 9,719,300.00 | 9,635,641.00 | **83,659.00** | **99.14** |
| 17 | Цэвэр, бохир ус | 136,800.00 | 361,560.00 | **-224,760.00** | **264.30** |
| 18 | Байрны түрээс | 3,960,000.00 | 3,960,000.00 | **0.00** | **100.00** |
| 19 | **Хангамж, бараа материалын зардал** | **10,732,200.00** | **10,732,200.00** | **0.00** | **100.00** |
| 20 | Бичиг хэрэг | 748,600.00 | 1,310,960.00 | **-562,360.00** | **175.12** |
| 21 | Тээвэр, шатахуун | 6,915,300.00 | 6,915,300.00 | **0.00** | **100.00** |
| 22 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,874,500.00 | 1,312,140.00 | **562,360.00** | **70.00** |
| 23 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,193,800.00 | 1,193,800.00 | **0.00** | **100.00** |
| 24 | **Нормативт зардал** | **641,500.00** | **641,500.00** | **0.00** | **100.00** |
| 25 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 641,500.00 | 641,500.00 | **0.00** | **100.00** |
| 26 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **356,400.00** | **356,400.00** | **0.00** | **100.00** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **27** | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 356,400.00 | 356,400.00 | **0.00** | **100.00** |
| **28** | **Томилолт, зочны зардал** | **2,738,000.00** | **2,738,000.00** | **0.00** | **100.00** |
| **29** | Дотоод албан томилолт | 2,738,000.00 | 2,738,000.00 | **0.00** | **100.00** |
| **30** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **26,199,700.00** | **25,873,100.00** | **326,600.00** | **98.75** |
| **31** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 25,632,900.00 | 25,632,900.00 | **0.00** | **100.00** |
| **32** | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 148,500.00 | 0.00 | **148,500.00** | **0.00** |
| **33** | Даатгалын үйлчилгээ | 99,000.00 | 0.00 | **99,000.00** | **0.00** |
| **34** | Тээврийн хэрэгслийн татвар | 69,300.00 | 4,900.00 | **64,400.00** | **7.07** |
| **35** | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 250,000.00 | 235,300.00 | **14,700.00** | **94.12** |
| **36** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,489,300.00** | **2,489,300.00** | **0.00** | **100.00** |
| **37** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,489,300.00 | 2,489,300.00 | **0.00** | **100.00** |
| **38** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **31,563,000.00** | **31,563,000.00** | **0.00** | **100.00** |
| **39** | **Бусад урсгал шилжүүлэг** | **31,563,000.00** | **31,563,000.00** | **0.00** | **100.00** |
| **40** | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 31,563,000.00 | 31,563,000.00 | **0.00** | **100.00** |
| **41** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **243,142,200.00** | **243,142,200.00** | **0.00** | **100.00** |
| **42** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **243,142,200.00** | **243,142,200.00** | **0.00** | **100.00** |
| **43** | Улсын төсвөөс санхүүжих | 243,142,200.00 | 243,142,200.00 | **0.00** | **100.00** |
| **44** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **8** | **9** | **-1** | |
| **45** | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 8 | 9 | **-1** | |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| **№** | **Үзүүлэлт** | **Гүйцэтгэл** |
|---|---|---|
| **1** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **8,500,000.00** |
| **2** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **8,500,000.00** |
| **3** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **8,499,600.00** |
| **4** | **Хангамж, бараа материалын зардал** | **3,567,600.00** |
| **5** | Бичиг хэрэг | 1,316,000.00 |
| **6** | Тээвэр, шатахуун | 2,251,600.00 |
| **7** | **Томилолт, зочны зардал** | **4,932,000.00** |
| **8** | Гадаад албан томилолт | |
| **9** | Дотоод албан томилолт | 4,932,000.00 |
| **10** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **400.00** |
| **11** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **400.00** |
| **12** | Улсын төсвөөс олгосон санхүүжилт,нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг | 400.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **8,500,000.00** |

| | | |
|---|---|---|
| **14** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **8,500,000.00** |
| **15** | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,500,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Орхон-Чулуут голын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Мөнгөншагай гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн Орхон-Чулуут голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18 -ны өдрийн 5 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Орхон-Чулуут голын сав газрын захиргаа нь “Усны нөөцийг ашиглаж болох боломжит нөөцийн хэмжээнд хэмнэлттэй, үр ашигтай ашиглах, нөхөн сэргээх, бохирдохоос урьдчилан сэргийлэх, усны талаарх бодлого, хөтөлбөр, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх” чиг үүрэг бүхий БОАЖЯ-ны харъяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Орхон-Чулуут голын сав газрын захиргаа нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 243.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 1.8 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе  шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 48 сая төгрөгөөр буюу 15 хувиар өсч материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн  дансууд байна.

*Хүснэгт 1.* Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт | Хувь |
|---|---|---|---|---|
| Бараа материал | 13.1 | 13.0 | (0.1) | -0.8 |
| Үндсэн хөрөнгө | 306.0 | 354.1 | 48.1 | 15.7 |
| **Нийт хөрөнгө** | **319.1** | **367.1** | **48.0** | 15.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 319.1 | 367.1 | 48.0 | 15.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн  дүн** | **319.1** | **367.1** | 48.0 | 15.0 |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл 0.8 хувиар буурсан байна.

Бараа материалын данс нь 13.1 сая  төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 25.6 сая төгрөг нэмэгдэж, тайлант онд 25.6 сая төгрөгийн зарцуулалт гарч, 13.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 15.7 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 306.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 52.6 сая төгрөг хөрөнгө нэмэгдсэн бол тайлант хугацаанд байгуулсан 4.5 сая төгрөгийн элэгдлээр буурч оны эцэст 354.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүн 179.4 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой.

*Хүснэгт 2.* Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 222.4 | 243.1 | 20.7 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 14.5 | 8.5 | (6.0) |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1.9 | | (1.9) |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 52.6 | 52.6 |
| **Үйл ажиллагааны орлого** | **238.8** | **304.2** | **65.4** |
| Цалин, шимтгэлийн зардал | 179.8 | 152.4 | (27.4) |
| Бусад бараа үйлчилгээний зардал | 61.5 | 71.9 | 10.4 |
| Урсгал шилжүүлэг | | 31.9 | 31.9 |
| **Үйл ажиллагааны зардал** | **241.3** | **256.2** | **14.9** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **(2.5)** | **48.0** | **50.5** |

Орхон-Чулуут голын сав газрын захиргааны санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 52.6 сая төгрөгөөр өссөн нь БОАЖЯ-аас 42.6 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 9.9 сая төгрөгийн барилгын засварын ажлуудтай мөн урсгал шилжүүлэг 31.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тэтгэвэрт гарч буй албан тушаалтны тэтгэмжтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 344.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 114.0 сая төгрөгөөр бууруулж, зардлыг 230.9 сая төгрөгөөр хянаж баталсан байна. Харин тайлант онд батлагдсан төсвийн дүнг 5 хувиар буюу 12.2 сая төгрөгөөр бууруулан тодотгожээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 243.1 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч, 242.8 сая төгрөгийг зарцуулж, 0.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, тайлант онд батлагдсан төсвийг 1.9 хувиар хэмнэж төсвийн хэмнэлтийг бий болгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар Орхон, Архангай аймгуудын БОГазраас усны тоо бүртгэл болон хамгаалалтын бүс тогтоох ажлын зардалд 8.5 сая төгрөгийн санхүүжилт ирснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлангийн жилд тус байгууллага усны тоо бүртгэл болон хамгаалалтын бүс тогтоох ажил хийгдсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 14 үндсэн зорилтын хүрээнд 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 86.8 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 243.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 99.9 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Албан томилолт, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.
- ОЧГСГЗ-ны төсвийг анх 230.9 сая төгрөгөөр баталсан бол тодотголоор 243.1 сая төгрөгөөр буюу 12.2 сая төгрөгөөр бууруулсан байна. Учир нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлууд 7.1 сая, тогтмол болон бусад зардал 5.1 сая төгрөгөөр бууруулсан байна.

Тайлант онд БОАЖЯамнаас 42.6 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 9.9 сая төгрөгийн барилгын засварын ажлууд хийгдсэн байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэл байхгүй тул судалгааг гаргаж ирүүлээгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

ОЧГСГЗахиргаа нь 2021 онд 140 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 137 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын *"Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай"* 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 8.1 % буюу 1.4 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43-р тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлагыг хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжиийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилты холбогдох шалгуурт тус тус бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар тайлант жилийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй зөрчилд Төсвийн тухай хуулийн 16.5.2 батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих зөвлөмж хүргүүлснийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

-----оОо-----

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа зөрчлийн утга | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | | |
| 1 | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | | |
| 1 | ОЧГСГЗахиргаа | | 2 | 1.4 | | | | | 1 | 1.4 | 1 | |
| Дүн | | | 2 | 1.4 | | | | | 1 | 1.4 | 1 | |
| Нийт дүн | | | 2 | 1.4 | | | | | 1 | 1.4 | 1 | |